



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 8/12

Хэрлэн сум

Г
Засвар болон тоног төхөөрөмж авах ажлын
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний
хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих Хэнтий аймгийн Батноров сумын Бэрх тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны их засвар, Бор-Өндөр цогцолбор сургуулийн дотуур байрны гадна фасадны засвар, Мал эмнэлгийн лабораторын тоног төхөөрөмж авах ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Э.Мөнх-Эрдэнэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Ц.Мягмар-Ариунаа Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: М.Хишигбаяр Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Цэрэнчимэд Төрийн бус байгууллагын төлөөлөл

Д.Оюун Төрийн бус байгууллагын төлөөлөл

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

